

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2009 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан удирдамжийн дагуу шалгалтын ажлын хэсэг 2009 оны 6 дугаар сарын 11- ний өдрөөс 6 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд “Нийслэл даатгал” ХХК-ийн санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааг газар дээр нь шалгахад, тус компани нь дүрмийн болон нөөцийн сангийн хөрөнгөнөөс 581.3 сая төгрөгийг “Пума” ХХК-д барьцаа хөрөнгөгүй, гэрээ байгуулалгүйгээр зээл олгосон байсан тул Хорооны 2009 оны 7 дугаар сарын хуралдаанаар “Нийслэл даатгал” ХХК-ийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудал хэлэлцэгдэж, Хорооны 2009 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 172 дугаар тогтоолоор тус компанийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 1 сарын хугацаатай түдгэлзүүлэх тухай шийдвэр гарсан.

Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа нь 2009 оны 8 дугаар сарын 28-ны өдөр дууссан бөгөөд тус компаниас “Пума” ХХК-д зээлдүүлсэн мөнгийг буцаан компанийн дансанд байршуулах талаар хийгдсэн ажлын талаарх мэдээлэл, холбогдох баримт бичиг, мөн тусгай зөвшөөрлийг сэргээж өгөхийг хүссэн хүсэлтийг Хороонд ирүүлсэн бөгөөд 2009 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 511.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 100 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг “Пума” ХХК нь “Нийслэл даатгал” ХХК-нд хөрөнгөд байршуулсан боловч 2009 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар дахин шалгаж үзэхэд тус компанийн Голомт банкны 2201113139 тоот төгрөгийн харилцахад 112,978,800.00 төгрөг, 2201113140 долларын харилцах дансанд 51,104.56 /Монгол банкны 2009 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн ханш-1414.08 төгрөг/- 72.265.936.20 төгрөг, Худалдаа хөгжлийн банкны 499076583 тоот төгрөгийн харицахад 20,986,802.64 төгрөг буюу **нийт 206,231,538.84** төгрөгийн дансны хуулгыг ирүүлсэн.

Касст 336,994,176.15 төгрөг байгаа гэсэн баримтыг ирүүлсэн бөгөөд дансанд буй бэлэн мөнгийг тоолохоор Даатгалын газрын мэргэжилтэн, улсын байцаагч Ж.Мядагноров, Э.Батболд нар “Нийслэл даатгал” ХХК-д очсон боловч мөнгө байгаа гэх сейф цоожтой,

түлхүүр нь тус компанийн ерөнхий захирал, хувь нийлүүлэгч Н.Нацагдоржид байгаа, Н.Нацагдорж захирал хөдөө явсан, холбоо барьж чадахгүй байгаа гэсэн шалтгаанаар тоолуулаагүй гэсэн танилцуулгыг Даатгалын газрын орлогч дарга П.Цэрэндэжид танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

“Нийслэл даатгал” ХХК нь тус компанийн дүрмийн сан болон нөөцийн сангийн хөрөнгийг бүрэн бүрдүүлж, холбогдох журамд нийцүүлэн байршуулах болон гаргасан зөрчлөө арилгах хүртэл хугацаагаар ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацааг сунгахаар шийдвэрлэв.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН